



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/370

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 3.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийхдээ энэхүү аргачлалыг мөрдөж ажиллахыг Газрын судалгаа шинжилгээ, бодлого төлөвлөлтийн газар (А.Амарсайхан), Газар зохион байгуулалтын хэлтэс (Ц.Ихбаяр), аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ аргачлал батлагдсантай холбогдуулан Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын (хуучнаар) 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн “Журам, заавар батлах тухай” тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Батлагдсан аргачлалын дагуу холбогдох байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалтын хэлтэс (Ц.Ихбаяр)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА  А.ЭНХМАНЛАЙ



1525011739

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий
газрын даргын 2025 оны 7-дугаар сарын 29-ны
өдрийн 3-дугаар тушаалын хавсралт
1370

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэхэд энэхүү аргачлалын дагуу хийнэ.

1.2. Энэхүү аргачлалын зорилго нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний (цаашид “төлөвлөгөө” гэх) хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ хийх, үнэлэх, төлөвлөгөөний баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, төлөвлөгөөний баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг дээшлүүлэхэд оршино.

1.3. Аргачлалын зорилтууд:

1.3.1. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үнэлэх, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлох;

1.3.2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй тохиолдолд түүний хэрэгжилтийг үнэлж, хэрэгжихгүй байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, төлөвлөгөөний баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох;

1.3.3. Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах.

ХОЁР. АРГАЧЛАЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил нь дараах төрөлтэй байна. Үүнд:

2.1.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

2.1.2. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

2.1.3. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө;

2.1.4. Сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө.

2.2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд дараах цагалбараар үнэлгээг хийж, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах, хэрэгжилт, үр дүнг дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлно. Үүнд:

2.2.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 4 жил тутамд 1 удаа, нийт 4-5 удаа үнэлгээ хийнэ.

2.2.2. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 4 жил тутамд 1 удаа, нийт 3-4 удаа үнэлгээ хийнэ.

2.2.3. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 3 жил тутамд 1 удаа, нийт 2 удаа үнэлгээ хийнэ.

2.2.4. Сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хууль, журамд нийцүүлэн жил бүр үнэлгээ хийнэ.

ГУРАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

3.2. Бусад төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймаг, нийслэлийн газрын алба зохион байгуулна.

3.3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдсэн ажлын үр дүнг Газар зохион байгуулалт хийх журамд заасан хугацааны дагуу газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.4. Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системд оруулах ажлыг суманд газрын даамал, аймаг, нийслэл, дүүрэгт газрын албаны газар зохион байгуулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, улсын хэмжээнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

3.5. Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй баг (цаашид “баг” гэх) хийнэ.

3.6. Багийн бүрэлдэхүүнд энэхүү аргачлалын 3.4-д заасан мэргэжилтэн болон тухайн байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй газар зохион байгуулалтын зөвлөх эсвэл мэргэшсэн инженер, тухайн байгууллагын хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн оролцоно. Хамтрагч байгууллагуудын албан хаагчдыг багийн бүрэлдэхүүнд нэмж оролцуулж болно.

3.7. Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлээр хяналт шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд энэхүү аргачлалын Хавсралт 1-т заасны дагуу нэгдсэн загвар хүснэгтээр гаргана.

3.8. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхдээ үр дүнд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний учир шалтгааныг тогтооно (Хавсралт 2-т заасны дагуу загвар хүснэгтээр хийнэ). Үр дүнд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнд хяналт, шинжилгээ хийх жишээг Хүснэгт 2-оор харуулав. Тус хэрэгжилтийн үнэлгээг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, дараагийн төлөвлөгөөнд тусгах ажлыг энэхүү аргачлалын 3.1, 3.2-т заасан байгууллагууд зохион байгуулна.

3.9. Сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг энэхүү аргачлалын Хавсралт 3-т заасны дагуу газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан гаргана.

3.10. Сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр үр дүнд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний учир шалтгааныг тогтоох хяналт шинжилгээний ажлыг суманд газрын даамал, нийслэл, дүүрэгт газрын албаны газар зохион байгуулалтын

төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Хавсралт 2-т заасан загвар хүснэгтийн дагуу хийнэ.

3.11. Сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ төлөвлөсөн нэгж талбарын байршлыг үндэслэлгүйгээр өөрчилсөн зөрчил илэрвэл тус арга хэмжээг хэрэгжээгүйд тооцож үнэлгээнээс хасна.

3.12. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд нэгтгэж, газрын нэгдмэл сангийн тайланд тусгана.

ДӨРӨВ. АРГА ЗҮЙ

4.1. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийхдээ тухайн төлөвлөгөөнд хавсаргасан “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төлөвлөсөн арга хэмжээг үнэлгээ хийгдэх үеийн бодитоор хэрэгжсэн арга хэмжээтэй харьцуулан гүйцэтгэлийг хувиар илэрхийлэх аргаар боловсруулна.

4.2. Гүйцэтгэлийг хувиар илэрхийлэхдээ “Бодит гүйцэтгэлийн индекс”-ээр гаргана.

4.3. Тоон үзүүлэлтгүй арга хэмжээний биелэлтийг гаргахдаа багийн бүрэлдэхүүн дэх газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэргэжилтэн, экспертийн үнэлэмжээр хувийг тооцон нийт олонхын саналаар эцэслэн тогтооно.

4.4. Хангалтгүй болон үр дүнд хүрээгүй арга хэмжээнүүдэд хяналт, шинжилгээ хийхдээ “хугацааны ашигт харьцаа” болон “төсвийн ашигт харьцаа”-гаар нэмж үнэлгээ хийнэ.

4.5. Төлөвлөгөөний гүйцэтгэл, биелэлтийг үнэлэх итгэлцүүрүүд:

4.5.1. Бодит гүйцэтгэлийн индекс нь төлөвлөгөөнд төлөвлөсөн ажлын тоо, хэмжигдэхүүн болон гүйцэтгэлийн бодит үр дүнг харьцуулан тодорхойлох бөгөөд тухайн арга хэмжээний хэрэгжилт хэдэн хувиар биелсэн болохыг илэрхийлнэ.

4.5.2. Төлөвлөсөн арга хэмжээ буюу төслийн эхэнд тогтоосон хэмжигдэхүйц үзүүлэлтийг (жишээ нь: км зам, га газар, м.кв барилга, байршил болон объектын тоо гэх мэт) бодит хэрэгжилт буюу үнэлгээ хийх үеийн гүйцэтгэсэн бодит арга хэмжээтэй харьцуулан хувиар илэрхийлэх хэмжүүр юм. Бодит гүйцэтгэлийн индексийг томъёо 1-ээр тодорхойлно.

$$\text{Бодит гүйцэтгэлийн индекс} = \left[\frac{\text{Бодит хэрэгжсэн арга хэмжээ}}{\text{Төлөвлөсөн арга хэмжээ}} \right] \times 100$$

(Томъёо 1)

4.5.3. Хугацааны ашигт харьцаа нь тухайн арга хэмжээний төлөвлөсөн хугацаа болон бодит хэрэгжилтийн хугацааны хоорондын харьцааг харуулна (томъёо 2).

$$\text{Хугацааны ашигт харьцаа} = \left[\frac{\text{Төлөвлөсөн хугацаа (хоног/сар)}}{\text{Бодит хэрэгжилтийн хугацаа (хоног/сар)}} \right] \times 100$$

(Томъёо 2)

4.5.4.Төсвийн ашигт харьцаа гэж төсөл хэрэгжих явцад батлагдсан төсөв болон бодитоор гарсан зардлыг харьцуулж, төсөв хэр үр ашигтай зарцуулагдсан эсэхийг үнэлэхэд ашиглагддаг шалгуур үзүүлэлт юм. Төсвийн ашигт харьцааг дараах томьёогоор тодорхойлно (Томьёо 3).

$$\text{Төсвийн ашигт харьцаа} = \left[\frac{\text{Төлөвлөсөн зардал}}{\text{Бодит зардал}} \right] \times 100$$

(Томьёо 3)

4.6.Төлөвлөгөөний гүйцэтгэл, биелэлтийг хувиар илэрхийлэх үйл ажиллагаа:

4.6.1.Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд энэхүү аргачлалын 4.5-д заасан бодит гүйцэтгэлийн индексийн дагуу үйл ажиллагаа нэг бүрээр нэгтгэн дүгнэж Хавсралт 1-ээр үнэлгээг гаргана.

4.6.2.Төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийг Хавсралт 1-т заасан нэгдсэн загвар хүснэгтээр гаргахдаа газрын нэгдмэл сан тус бүрийн эсвэл тухайн “Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний бүлэг бүрийн бүх үйл ажиллагааны арифметик дунджаар, эцсийн гүйцэтгэлийг бүлэг нэг бүрийн арифметик дунджаар тухайн төлөвлөгөөний эцсийн нэгдсэн биелэлт, гүйцэтгэлийг хувиар (100%-д) дүгнэнэ. Төлөвлөгөөний хэрэгжилтийг бодит гүйцэтгэлийн индексээр үнэлэх жишээг Хүснэгт 1-ээр харуулав.

4.6.3.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад үнэлгээ хийхэд үе шатны хэрэгжилт хамгийн бага хувьдаа хүрсэн тохиолдолд “тодорхой үр дүнд хүрсэн”, хамгийн бага хувьдаа хүрээгүй бол “хэрэгжилт хангалтгүй” гэж дүгнэнэ. Үүнд:

4.6.3.1.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хамгийн бага хувиар тооцоход эхний дөрвөн жилд 10–15%, дараагийн дөрвөн жилд 15–35%, гурав дахь дөрвөн жилд 35–55%, дөрөв дэх дөрвөн жилд 55–65%, тав дахь дөрвөн жилд 65–85% биелсэн байх шаардлага тавигдана.

4.6.3.2.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хамгийн бага хувиар тооцоход эхний дөрвөн жилд 15–20%, дараагийн дөрвөн жилд 20–40%, гурав дахь дөрвөн жилд 40–60%, дөрөв дэх дөрвөн жилд 60–85% биелсэн байх шаардлага тавигдана.

4.6.3.3.Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хамгийн бага хувиар тооцоход эхний таван жилд 20–60%, зургаа, долоо дахь жилд 60–85% биелэлт хангах шаардлага тавигдана.

4.6.3.4.Сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хамгийн бага хувиар тооцоход жилийн эцэст 60%-с доошгүй биелэлт, нэмэлт өөрчлөлт оруулсан төлөвлөгөөнд 80%-с доошгүй биелэлт хангах шаардлага тавигдана.

4.6.4.Төлөвлөгөө хэрэгжиж дууссаны дараах биелэлт 60-85% болон түүнээс дээш хувьтай бол үр дүнтэй хэрэгжсэн, 50-60% бол тодорхой үр дүнд хүрсэн, 30-49% бол хангалтгүй хэрэгжсэн, 0-29% бол үр дүн гараагүй гэж дүгнэнэ.

4.7.Төлөвлөгөөний биелэлтийг Хавсралт 1-ээр дүгнэсний дараа үр дүнд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнд хяналт, шинжилгээг Хавсралт 2-ын дагуу гүйцэтгэнэ.

4.8. Үр дүнд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнд дараах шалгуураар хяналт, шинжилгээ хийж, хэрэгжилтийг хангах зөвлөмжийг Хавсралт 2-ын цаашид авах арга хэмжээ баганад тусгана. Үүнд:

4.8.1.Төлөвлөгөөний баримт бичгийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшний тоон утга, хэрэгжих хугацаа, санхүүжилтийн дүнг бодитой урьдчилан тооцоолсон эсэх;

4.8.2.Төлөвлөгөөний баримт бичгийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн нөөц хүрэлцээтэй эсэх, түүнийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байгаа эсэх;

4.8.3.Төлөвлөлтийн баримт бичгийн үр дүн нь зорилтот түвшинд хүрэх боломжтой эсэх;

4.8.4.Холбогдох төрийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамлын зүгээс төлөвлөгөөний баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн төсөвт тусгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх;

4.8.5.Холбогдох төрийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамлын зүгээс эрх бүхий этгээд, шийдвэр гаргагч нарт төлөвлөгдсөн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хангалттай мэдээлэл, мэргэжил аргазүйгээр хангаж ажилласан эсэх;

4.8.6.Төлөвлөгөөний баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа эсэх;

4.8.7.Төлөвлөлтийн арга хэмжээ нь анх төлөвлөсөн байршил, хэмжээндээ хэрэгжсэн эсэх.

ТАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

5.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулга мэдээлэл хийж, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх талаарх чиглэл, зөвлөмжийг өгч хамтран ажиллана.

5.2.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулга мэдээлэл хийж, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх талаарх арга хэмжээний саналыг боловсруулж хамтран ажиллана.

5.3.Аймаг, нийслэлийн газрын алба төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ өгч төлөвлөгөөнд өөрчлөлт, нэмэлт, тодотгол хийх, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй холбоотой шийдвэрлүүлэх санал боловсруулах ажлыг зохион байгуулна.

5.4.Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад үнэлгээ хийхэд дараалан 2 удаа үнэлгээний үр дүнгээр төлөвлөгөө нь гүйцэтгэлийн хамгийн бага хувьдаа хүрээгүй

тохиолдолд хөрөнгө оруулалтын эх үүсвэргүй, хэрэгжээгүй шалтгааныг тодорхойлж, өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллага хууль, журамд нийцүүлэн зохион байгуулна.

5.5.Багийн бүрэлдэхүүнд газар зохион байгуулалтын зөвлөх инженер, мэргэшсэн инженер оролцсон бол түүний ажилд шаардагдах төсөв, зардлыг тухайн шатны газрын алба хариуцна.

Хүснэгт 1. Төлөвлөгөөний хэрэгжилтийг бодит гүйцэтгэлийн индексээр үнэлэх жишээ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Суурь үзүүлэлт	Төлөвлөсөн үр дүн	Бодит үр дүн	Бодит гүйцэтгэлийн индекс %	Дүгнэлт
0	1	2		3	4	5	6
2.2. Суурьшлын бүсэд хэрэгжүүлэх ГЗБ-ын арга хэмжээ							
2.2.1	Аймаг, нийслэлийн ЕТ-нд тусгагдсан хот, тосгон бусад суурины эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоох газар зохион байгуулалтыг хийх	2025-2028	-	10 сумын хот, тосгон бусад суурины эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоохоор төлөвлөсөн.	8 сумын хот, тосгон бусад суурины эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоосон.	$(8/10) \times 100 = 80\%$	Үр дүнтэй хэрэгжсэн
	Хот суурины эдэлбэр газруудын хил заагийг шаардлагатай газруудад тэмдэгжүүлэх		-	10 сумын хот суурины эдэлбэр газруудын хил заагийг шаардлагатай газруудад тэмдэгжүүлэхээр төлөвлөсөн.	5 сумын хот суурины эдэлбэр газрын хил заагийг тэмдэгжүүлсэн.	$(5/10) \times 100 = 50\%$	Тодорхой үр дүнд хүрсэн
2.2.2	ГНС-ийн ангиллын шинэчилсэн тооллого бүртгэл хийх	2028-2030	-	10 сумын шинэчлэн газрын нэгдмэл сангийн шинэчилсэн тооллого бүртгэл хийхээр төлөвлөсөн.	10 сумын газрын нэгдмэл сангийн шинэчилсэн тооллого бүртгэл хийгдсэн.	$(10/10) \times 100 = 100\%$	Үр дүнтэй хэрэгжсэн
2.2.4	Шинэчлэн тогтоосон хот суурины эдэлбэр газрыг газрын тухай хуулийн 23.2.9-т заасны дагуу Засгийн газрын шийдвэрээр" хот суурин газрын ангилалд бүртгэх, ГНС-ийн ангиллын шинэчилсэн тооллого бүртгэл хийх	2030-2032	-	10 сумын шинэчлэн тогтоосон хот суурины эдэлбэр газрыг газрын тухай хуулийн 23.2.9-т заасны дагуу Засгийн газрын шийдвэрээр" хот суурин газрын ангилалд бүртгүүлэхээр төлөвлөсөн.	Засгийн газрын шийдвэрээр" хот суурин газрын ангилалд шилжүүлсэн.	$(10/10) \times 100 = 100\%$	Үр дүнтэй хэрэгжсэн
	2.2.5	Суурьшлын тэлэх боломжтой нөөц бүсэд ГЗБ-ын нарийвчилсан зураг төслүүдийг хийлгэх	2030-2032	-	10 сумын суурьшлын тэлэх боломжтой нөөц бүсэд ГЗБ-ын нарийвчилсан зураг төслүүдийг хийлгэхээр төлөвлөсөн.	4 сумын суурьшлын тэлэх боломжтой нөөц бүсэд ГЗБ-ын нарийвчилсан зураг төслүүдийг хийж гүйцэтгэсэн.	$(4/10) \times 100 = 40\%$
2.2.6	Батлагдсан хот суурины эдэлбэр газар дах суурьшлын нөөц бүсэд байр зүйн зураглал, инженер геологийн судалгааг хийх	2033-2035	-	10 сумын хот суурины эдэлбэр газар дах суурьшлын нөөц бүсэд байр зүйн зураглал, инженер геологийн судалгаа хийхээр төлөвлөсөн.	Хийгдээгүй	0%	Үр дүн гараагүй
2.2.7	Хот, тосгон бусад суурины эдэлбэр газрын хил заагийг батлагдаж байгаагаар холбогдуулсан газрын үнэлгээ, татварын бүсийг	2032-2033	-	10 сумын газрын үнэлгээ татварын бүсийг шинэчлэн тогтоохоор төлөвлөсөн.	10 сумын газрын үнэлгээ, татварын бүсийг шинэчлэн тогтоосон.	$(10/10) \times 100 = 100\%$	Үр дүнтэй хэрэгжсэн

Улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Суурь үзүүлэлт	Төлөвлөсөн үр дүн	Бодит үр дүн	Бодит гүйцэтгэлийн индекс %
0	1	2	3	4	5	6

Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

[illegible]